



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН БОЛОН
СҮХБААТАР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ПҮРЭВСҮРЭНГИЙН
ЭНХЖАРГАЛ ТАНАА**

2020.09.03 № 07-2020/06-НТ-58

танай _____ -ны № _____ -т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн болон Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Пүрэвсүрэнгийн Энхжаргалын мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сэлэнгэ аймгийн болон Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч П.Энхжаргал нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050" холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

018020791


Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч П.Энхжаргалын Сэлэнгэ аймгийн болон Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч П.Энхжаргалын мөрийн хөтөлбөр /...³... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сэлэнгэ аймгийн болон Сүхбаатар сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Ч.ЭНХТУЯА

СЭЛЭНГЭ АЙМАГ БОЛОН СҮХБААТАР СУМЫН 2020 ОНЫ ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ПҮРЭВСҮРЭНГИЙН ЭНХЖАРГАЛЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР



УРИА: "ХАМТДАА БҮТЭЭЖ, ХАМТДАА ХӨГЖИЦГӨӨ"

1. Сүхбаатар сумын хөгжил, дэвшил, бүтээн байгуулалтад манлайлан оролцох иргэдийнхээ бүтээлч сэтгэлгээг өрнүүлэн, хамтарч ажиллана.
2. Иргэдэд шаардлагатай, тэдний оюуны болон бие бялдрын хөгжилд ач тусаа өгөх шинэлэг үйл ажиллагааг нэвтрүүлэхийг эрэлхийлсэн бүтээлч сэтгэлгээ, шинэ санаа, шилдэг бүтээл хийх санаачилгатай, хүсэл сонирхолтой залуучуудыг дэмжин, тусална.
3. Айл өрх бүрд "Хашаандаа сайхан амьдаръя" хөтөлбөр хэрэгжүүлж, эко орчин бүрдүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
4. Сум орон нутгаас иргэдэд чиглэсэн аливаа үйл ажиллагаанд иргэдийг идэвхтэй оролцуулах ажлыг зохион байгуулна.
5. Ахмадаа халамжлах, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, айл өрхөд хандсан сайн дурын дэмжлэг туслалцаа үзүүлэх аян, арга хэмжээнүүдэд идэвхийлэн оролцож, ард иргэдийнхээ хүмүүнлэг, энэрэнгүй сэтгэлийг нэгтгэн ажиллахад хичээнгүйлэн оролцоно.
6. Найрсаг Сэлэнгэчүүд, аз жаргалтай Сүхбаатар сумыг бий болгоход иргэдтэйгээ хамтран барилга, байшингийн өнгө үзэмжийг сайжруулах, хашаа хороогоо нэгэн жигд өнгөөр будаж, гудамж талбайгаа эмхлэх, цэвэр цэмцгэр орчин бүрдүүлэх ажлыг зохион байгуулна. Бүтээлч өрх, бүтээлч баг болохын төлөө хамтдаа идэвх зүтгэл гарган ажиллана.
7. Сэлэнгэ аймгийн төвийн хөгжлийг хурдасгах, хүнсний аюулгүй байдлыг хангах, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэлээр ажиллана.
8. Газрын тухай хуулийн дагуу иргэдэд 1 удаа үнэ төлбөргүй газар өмчлөх үйл ажиллагааг идэвхжүүлж, түргэн шуурхай шийдвэрлүүлэхэд анхаарч холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.
9. Ард, иргэдийг "Жижиг, дунд үйлдвэрлэл" эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хууль эрх зүйн болон мэргэжлийн байгууллагын заавар зөвлөмжөөр хангах ажлыг зохион байгуулна.
10. Орон нутагт бялдаржуулах талбай олноор бий болгох, эрүүл мэндээ дэмжих таатай орчин бүрдүүлэх санал, санаачилгыг дэмжиж, хамтарч ажиллана.
11. Ган зам 7-р багийн хэмжээнд жил бүр хавар, намрын улиралд мод, бут тарих аяныг уламжлал болгон зохион байгуулна.
12. Гудамж, зам, талбай, орон сууцны гэрэлтүүлэг, камержуулалтын ажлыг нэмэгдүүлэх, замаас ус зайлуулах суваг, үерийн даланг сайжруулах, засварлах, авто замын гарц, тэмдэг, тэмдэглэгээг сайжруулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
13. Залуу үеийг хөгжүүлэх зорилгоор "Зөв төлөвшил, зөв иргэн" хөтөлбөрийг ерөнхий боловсролын сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газруудын оролцоотойгоор зохион байгуулж ирээдүйд өндөр соёлтой, хүмүүжил, сахилга баттай, өв тэгш, бүтээлч, манлайлагч иргэдийг бэлтгэхийг дэмжинэ.



14. Иргэд, айл өрхийн амьжиргааг дээшлүүлэх, тэдэнд тулгарч буй аливаа асуудлыг шийдвэрлэхэд анхааран ажиллана.
15. Орон нутагт үлгэр жишээ болж буй иргэдийг сум, орон нутгаас урамшуулах боломж нөхцөлийг судалж, холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлнэ.
16. Хөдөлгөөний хомсдолыг арилгах зорилгоор ажлын байрны дасгал, хөдөлгөөнийг аж ахуйн нэгж байгууллагууд өдөрт 20-30 минутын хугацаа зарцуулдаг байх уриалга гарган, уламжлал болгон хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
17. Залуу, өсвөр үеийнхэнд архи, тамхины хор уршиг, муу зуршлаас хол байлгах талаарх сургалт сурталчилгааг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
18. Орон сууцны гудамж талбайд хүүхэд багачуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, цахим ертөнцөөс хол байлгах, амьд харилцаа бий болгох, тоглох орчноо хайрлан хамгаалдаг болгоход анхаарч бие бялдар, оюун ухааныг хөгжүүлэх тоглоомын орчныг бий болгох чиглэлээр ажиллана.
19. "Спортлог Сэлэнгэчүүд" хөтөлбөрийг санаачлан бүтээлч, эвсэг, спортлог байдлыг хангах зорилгоор ахмад, дунд, залуу үеийнхнийг хамарсан найрсаг уралдаан, тэмцээнийг төрөл бүрээр уламжлал болгон зохион байгуулна.
20. Орон сууцны байрнуудад оршин суугчид болон сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааг идэвхжүүлж, хамтын ажиллагааг сайжруулах чиглэл баримтална.
21. "Ухаан далай" номоос эхтэй уриалга гаргаж оршин суугчдаа номтой нөхөрлүүлэх зорилгоор ном солилцооны өдөртэй болоход иргэдээ уриалж ажиллана.
22. Үлгэр жишээч "Ган зам" багийг бий болгохын төлөө оршин суугчидтайгаа хамтарч, тэдний дуу хоолойг сонсож, сум, орон нутагт хэрэгжүүлэх шаардлагатай бүтээлч ажил, хөгжил дэвшилд хувь нэмэр оруулахуйц санал санаачилгыг нь холбогдох байгууллагуудад уламжлан, шийдвэрлүүлнэ.
23. Ахмадуудаа асран хамгаалах, тэдний эрүүл мэндийг хамгаалах, тэдэнд үзүүлэх үйлчилгээг сайжруулах зорилгоор Ахмадын сувилал, Биеийн тамир спортын газартай хамтран ажиллана.
24. Багийн хэмжээнд эмх замбараагүй, өнгө үзэмжид сөрөг нөлөө үзүүлэхүйц хашаа, барилга байгууламжийг орон нутгийн мэргэжлийн байгууллагуудтай хамтран өнгө үзэмжийг нь сайжруулах, тухайн барилга байгууламжийг өөр зориулалтаар ашиглаж болохоор бол сэргээн засварлах, шаардлагатай бол газрыг чөлөөлөх, дахин төлөвлөлтөд оруулах зэрэг асуудлыг Сүхбаатар сумын болон Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд санал оруулж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.
25. УБТЗ-ын Сүхбаатар зангилааны төмөр замчидтайгаа хамтарч төмөр замын вокзалын ойр орчим, "Цагаан эрэг" цогцолборт цэцэрлэгжүүлэлт хийж, орон нутгийн өнгө үзэмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

Бие даан нэр дэвшигч

П.Энхжаргал

2020 оны 07-р сарын 24